

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	8
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	9
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	9
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	9
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.12. Шилэн дансны мэдээлэл	11
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
3. Менежментийн захидал	13
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	15
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	17
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	19
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	21
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	22
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	24
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	25

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд
МУҮНС	Монгол Улсын үндэсний номын сан
МУИС	Монгол улсын их сургууль
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
УҮХ	Улсын үйлчилгээний хэлтэс



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
НОМЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.ИЧИНХОРЛОО ТАНАА

2020.02.21 № 06/563
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын үндэсний номын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын үндэсний номын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол улсын үндэсний номын сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол Улсын үндэсний номын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Б.Ичинхорлоо танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, авлага, өглөг, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын үндэсний номын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын үндэсний номын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 10 дугаар сарын 30-наас 2020 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Эс Жи Эм Ди -Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын үндэсний номын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 18 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын үндэсний номын сангийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Соёлын өв, оюуны бүтээлийг цуглуулан баяжуулж, хадгалан хамгаалж, нээлттэй хүртээмжтэй мэдээллээр үйлчлэх, түгээх хойч үед өвлүүлэн үлдээх”-д оршино.

Монгол Улсын Номын сангийн тухай хууль, Монгол Улсын үндэсний номын сангийн дүрэмд тус номын сангийн зорилгыг “Гар бичмэл, барын ном, эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл, Монгол Улсад хэвлэгдсэн ном, сонин сэтгүүл болон хэвлэлийн бусад бүтээгдэхүүн, чухал хэрэгцээтэй гадаадын ном зохиол, тогтмол хэвлэлийг бүрдүүлэн хадгалах, бүртгэл мэдээллийн сан бий болгох, уншигчдад шуурхай үйлчлэх, бусад номын сангуудыг мэргэжил арга зүйн удирдлага, мэдээллээр хангах” гэж тодорхойлсон.

БСШУС-ын 2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/58 дугаар “Дүрэм, бүтэц батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралтын 2.2 дахь хэсэгт Үндэсний номын сан үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг:

2.2.1. Ном, хэвлэлийн бүтээгдэхүүний үндэсний сан хөмрөг бүрдүүлэх зорилгоор баримтат өвийн зайлшгүй хамгаалах сан хөмрөгийг бүрдүүлэх, хадгалах, хамгаалах;

2.2.2. Эртний болон орчин үеийн ном, хэвлэлийн бүтээгдэхүүн, мэдээллийн бусад эх сурвалжийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, сэргээн засварлах, хадгалах, хамгаалах, олон нийтэд сурталчлан таниулах;

2.2.3. Номын сан, ном зүй, ном судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг бие даан хийхийн зэрэгцээ бусдаар захиалан гүйцэтгүүлэх;

2.2.4. Үндэсний ном зүй болон улсын нэгдсэн каталогийн мэдээллийн нэгдсэн санг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх;

2.2.5. Түүх соёлын дурсгалт зүйлд хамаарах ном, судрыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу бүртгүүлж, хамгаалах;

2.2.6. Бусад номын санг харьяалал харгалзахгүй Монгол Улсын хэмжээнд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

2.2.7. Номын сангийн үйлчилгээ эрхлэх, уншлагыг дэмжих олон талт ажил зохион байгуулах;

2.2.8. Салбарын болон байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр сургалт зохион байгуулах, гарын авлага, материал боловсруулах, ном товхимол гаргах;

2.2.9. Байгууллагын чиг үүрэгт хамаарах асуудлаар ижил, төстэй гадаад, дотоодын байгууллагатай хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулах, гадаад, дотоодын номын сан хоорондын ном солилцоог өргөжүүлэх;

2.2.10. Номын сан, ном зүйн мэдээллийг автоматжуулах, үйл ажиллагаандаа орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, цахим мэдээллийн санг бий болгох;

2.2.11. Номын сангийн сан хөмрөгийн эргэлтэд байнга судалгаа хийж, бүрдүүлэлтийн чанарыг сайжруулах арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

2.2.12. Номын сангийн бичиг баримтын бүрдүүлэлт, архивын нэгжийг Архивын тухай хууль, “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичиг” MNS 5140-1:2011, MNS 5140-2:2011, стандарт, “төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ыг тус тус мөрдөн бүрдүүлж, архивд шилжүүлэх;

2.2.13. Сан хөмрөгт хадгалагдаж байгаа хэвлэлийн бүтээгдэхүүнийг анхан шатны бүртгэл, хөрөнгийн бүртгэлд тусгах, номын тооллого хийх ажлыг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (Шинэчилсэн найруулга);
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль;
- ХХОАТ-ын тухай хууль (Шинэчилсэн найруулга);

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САНГИЙН 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ОНЦЛОХ АЖЛУУД

Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг "Үндэсний хөгжлийн цогц бодлого", Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган стратегийн 10 зорилтын хүрээнд 81 ажил, арга хэмжээг 98.9% гүйцэтгэн ажилласан байна.

МУҮНС-гийн 2019 онд гүйцэтгэсэн ажлын тайлангаас 5 гол зорилт, 18 арга хэмжээний хүрээнд хийгдсэн онцлох ажлуудаас:

1. Соёлын өвийн бүртгэл, хадгалалт хамгаалалтын хүрээнд:
 - 1.1. МУҮНС-гийн Үнэт ховор номын фондын тооллого
Түүх соёлын хөдлөх зүйлийн 2018-2019 оны улсын тооллогыг БСШУС-ын Сайдын 2018 оны 11-р сарын 30-ны А/756 дугаар тушаалаар томилогдсон Монголын Үндэсний номын сангийн Үнэт ховор номын фондын дурсгалт зүйлд тооллого хийх салбар комисс холбогдох хууль тогтоомж, удирдамжийн дагуу тооллогын ажлыг зохион байгуулж, нийт 516 дэсийн өвийг бүрэн тоолж дуусган тайланг гаргаж, холбогдох газарт хүргүүлэв.
 - 1.2. Сан хөмрөгт хадгалагдаж буй даавуун өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлсэн.
Үндэсний номын санд хадгалагдаж буй Төв Азийн нүүдэлчдийн оюуны соёлын нандин өв болох даавуун дээрх өвүүдийн хадгалалт хамгаалалтын орчинг сайжруулж, дахин гэмтэх эрсдэлийг бууруулан, хойч үедээ үлдээхэд зорилгоор ЗГХА, Соёл Урлагийн газрын төслөөр зориулалтын тавиур, шүүгээгээр хангах, сэргээн засварлах материал авах 13,200,000 төгрөгийн төсөл амжилттай хэрэгжиж, дэлгэмэл өвийг хадгалах том форматтай шүүгээ /цоожтой/ 6 ш, хуйлмал өвийг хадгалах сайжруулсан ган тавиур 1 ш, 100 ш краф цаасан сав, ном судрыг сэргээн засварлах, хамгаалах муутуу цаас авсан.
 - 1.3. Үндэсний бичиг үсгийн дурсгал, баримтат өвийг сурталчлах, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан талаар:
"Үндэсний бичиг үсгийн баяр-2019" арга хэмжээний хүрээнд:
 - Нээлтийн арга хэмжээг МҮОНРТ-ийн 2 дугаар сувгаар нэвтрүүлсэн ба 200 гаруй хүн оролцсон.
 - 2018 оны "Шилдэг номын сан"-г шалгаруулж, Үндэсний номын сангийн нэрэмжит "Ном цом" шагналаар Хөвсгөл аймгийн ННС-г шалгарууллаа.
 - Зохиогчийн гарын үсэгтэй болон хэвлэлийн газруудын номын худалдаа
 - "Даавуу, торгон дээрх үндэсний баримтат өв" үзэсгэлэн
 - "Номын сангийн үйл ажиллагааны тайлан боловсруулах арга зүйн зөвлөмж" сургалт
 - Даавуун артай соёлын баримтат өвийн өнөөгийн байдал" сэдэвт эрдэм шинжилгээ –онол практикийн хурал /эмхэтгэл хэвлүүлсэн/
 - 1.4. "Mongolian Heritage - Mongolian script" үзэсгэлэн
НҮБ-ын төв байрны үзэсгэлэнгийн танхимд Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэгийн санаачилгаар "Mongolian Heritage - Mongolian script" монгол бичгээр хэвлэгдсэн орчин үеийн номын үзэсгэлэнг 5 дугаар сарын 15-20-ны өдрүүдэд зохион байгуулж, Үндэсний Номын Сангийн бэлтгэл, солилцоогоор болон хувь хүмүүсээс цуглуулсан монгол бичгийн номуудыг НҮБ-ын гишүүн орнуудын элчин сайд нар, зочид, төлөөлөгчдөд сурталчиллаа.
 - 1.5. Монгол улсын сүүлчийн хаан VIII Богд Жавзандамба хутагтын мэндэлсний 150 жилийн ойн хүрээнд:
 - Шашин төрийг хослон баригч, наран гэрэлт түмэн наст, оройн дээд, Очирдарь хувилгаан Наймдугаар Богд Жавзандамба хутагтын мэндэлсний 150 жилийг ойг тэмдэглэх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг гардаж авч, үзэсгэлэн, эрдэм шинжилгээний хурал зохион байгууллаа.

- VIII БОГДЫН БУМАН ЗАРЛИГ” номыг Монголын сүүлчийн хаан Богд Жавзандамбын төвөд хэлээр туурвисан сүнбүм зохиолыг уншигч, судлаачдад зориулан МУҮНС-аас эрхлэн хэвлэн гаргасан.
- 1.6. "Дэлхийн номын сангууд дахь сурвалж бичгийн өв" олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан.
- МУИС-ийн номын сан, МУИС-ын Монгол судлалын хүрээлэнтэй хамтран 8 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд оролцсон зохион байгуулсан ба хуралд гадаадын 22 эрдэмтэн, нийт 32 илтгэгч оролцлоо.
2. Номын сан судлалын онолын асуудалд судалгаа хийж, номын санчдын хүртээл болгож, эрдэм шинжилгээ судалгааны ажлыг эрчимжүүлэх хүрээнд:
- 2.1. Номын сангийн арга ажиллагааны талаар аргачлал, зөвлөмж, заавар, журам боловсруулах ажлын хүрээнд:
Тайлангийн хугацаанд нийт 2 стандартын төсөл, 1 журмын төсөл, 2 аргачлал, 2 зөвлөмж, 7 судалгаа хийж дүгнэн хэлэлцүүлснээс гадна шинэ барилгатай холбоотой судалгаа, төсөл, төсвүүдийг боловсруулсан болно.
- Мэргэжил арга зүйн холбоотой хурал, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах ажлаар нийтийн болон бусад холбогдох номын сангийн 233 номын санчдад 8 удаа мэргэжил аргазүйн холбоотой сургалт, семинарыг зохион байгуулав.
 - Мэргэжил онол арга зүйн “Номын санч” сэтгүүлийн №1, 2 дугаарыг нийтийн номын сангуудад хуваарилан өгч, номын санчдын мэдлэг, мэргэжил, шинэлэг судалгаа, олон улсын болон өөрийн орны номын сангуудын
 - Улсын хэмжээний нийтийн номын сангуудын зөөврийн үйлчилгээ үзүүлсэн мэдээ, тайлан, судалгааг улиралд 1 удаа гаргаж байна.
- 2.2. Бүтээл хэвлүүлсэн талаар:
Номын сан, ном судлалын болон уншигч, судлаачдын эрэлт хэрэгцээнд нийцсэн 6 ном бүтээлүүд, эрдэм шинжилгээний илтгэл өгүүлэл 21 гадаад, дотоодын судалгааны сэтгүүл, хэвлэлд нийтлэгдсэн.
3. Лавлагаа- номзүйн үйлчилгээг боловсронгуй болгох, уншигчдад мэдээлэл-номзүйн үйлчилгээг үзүүлэх чиглэлээр:
“Номын сангийн тухай хууль”-ийн 9.2-р зүйлийг хэрэгжүүлэх: Ерөнхий, салбар номзүйг системтэй хөгжүүлэх, Үндэсний номзүйн бүртгэлийг бэлтгэх, лавлагаа номзүйн үйлчилгээ үзүүлэх бие даасан 5 номзүйн бүртгэл, 2 санамж өгөх номзүйг бэлтгэх хэвлүүлснээс гадна Дархан-Уул, Ховд, Говь-Алтай аймгийн Төв номын сангаас бэлтгэн гаргасан орон нутгийн ба санамж өгөх номзүйг хянаж засварлан оролцов.
4. Үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд:
Уншлага үйлчилгээнд уншигч, үйлчлүүлэгчдийн ая тухтай байдал, эрэлт хэрэгцээнд тулгуурлан, харилцааны соёлыг эрхэмлэн ажиллахыг зорьсон.
- 4.1. Уншигчийн үнэмлэхийг батлагдсан журмын дагуу уншигчийн үнэмлэхний бэлдцийг ашиглан дугаарыг товгор хэвлэлээр хэвлүүлэх, шинэчилсэн лого болон бусад бичвэрийг хянаж загварыг өгч “Ном хур” хэвлэлийн газартай гэрээ байгуулан, үнэмлэхийг хэвлүүлснээр гараар бичсэн дугаар бүдгэрэх, арилах асуудал тулгарахаа больсон.
- 4.2. Үндэсний номын сан – Уншлага үйлчилгээ фэйсбүүк хуудас ажиллуулж, уншигчдад 168 шинэ мэдээ, мэдээллийг өгөх, шинэ номын болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг тухай бүр сурталчилж байна.
- 4.3. Хандлагаа өөрчилж-Хамтдаа хөгжье” 2 сарын аяны үйл ажиллагааг зохион байгуулсан. Энэ аяны хүрээнд "Эерэг хандлагатай хэлтэс", "Ажлын байрны дасгал хөдөлгөөн хэвшүүлсэн хэлтэс" шалгаруулж, "Хувь хүний хандлага байгууллагын хөгжилд нөлөөлөх нь" сэдвээр зохион байгуулсан эсээ бичлэгийн уралдаанд 4 хүн

- оролцож, бичлэгийн ур чадвар, хэл найруулга, шинэлэг санааг дэвшүүлж "Шилдэг илтгэгч"-ээр УҮХ-ийн номын санч П.Энхээ нар шалгарчээ.
- 4.4. Уншлага үйлчилгээний номын санчид болон цэвэрлэгээ үйлчилгээний ажилтнуудад ажлын хувцсаар хангах арга хэмжээ авсан.
5. Гадаад, дотоодын хамтын ажиллагаа:
- 5.1. Төвд номыг дижиталчлах төслөөр 2,494 судар баринтаг (багц) бүртгэсэн. Каталогт нийт 14,950 гарчиг бүртгэж, түүнээс 1,058 баринтаг судрын 313,720 хуудас цахим хэлбэрт орсон бөгөөд 910 баринтаг /багц/ судар зургийн боловсруулалтад орж бүрэн дууссан бөгөөд BDRС веб сайтад байршаад байна. Цахим хэлбэрт орсон судрууд шинэ баринтаг, донтор хаяг хэвлэн фондод буцаан байрлуулсан ба бүртгэлийн систем болон архивлан хадгалах үйл ажиллагааг хянаж аюулгүй байдлыг хангаж ажилласан.
- Төслийн мэдээлэл, бүртгэсэн болон цахим номын мэдээлэл (<http://nlm.asianclassics.org/en>) цонх МУҮНС-ийн цахим хуудсанд байршсан.
- 5.2. МУИС-ийн Ази судлалын тэнхимийн багш доктор Б.Ундрахын санаачилсан төслийн хүрээнд Дорно дахины сан хөмрөгийн хятад ном хэвлэлийн каталог, бүртгэлийг сайжруулах зорилгоор гэрээ байгуулан хамтран ажиллалаа. "Дорно дахины сан хөмрөгийн Коха программд оруулах, каталогжуулах аргачлал" боловсруулж, нийт Хятад хэлээрх 16,732 нэрийн 30,509 номыг каталогийн программд шивж оруулж, карт каталогийг шинэчлэн зохион байгуулж, бар коджуулсан.
- 5.3. ШУА-ийн Түүх Археологийн хүрээлэн, Архивын Ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд торгон өргөмжлөл, бичгүүдийн судалгаа хийж, "Хаадын зарлиг" өргөмжлөл, жуух бичгийн каталог хэвлүүлсэн.
- 5.4. Богд хааны мэндэлсний 150 жилийн ойд зориулан "Дээрхийн уг эх оршивой. монголын богдууд" есөн боть бүтээлийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны захиалгаар эрхлэн хэвлэснийг эрдэмтэн судлаачиддаа өргөн барив.
- 2019 оны есдүгээр сарын 9-нээс арван нэгдүгээр сарын 9-нийг хүртэл хоёр сарын турш Монгол Улсын Үндэсний номын сан, Тайванийн Төв номын сантай хамтран дөрвөлжин үсэг зохиогдсоны 750 жилийн ойд зориулан "Их Монгол Улсын соёлын өв, нангиад соёл иргэншлийн ул мөр" сэдэвт үзэсгэлэнг зохион байгууллаа. Монгол сурвалжийн өвд хамаарах 31 хуйлмал бичээс, 27 нэрийн 43 ном, 8 хаадын хөргийг ҮНС-гийн сан хөмрөгт өгсөн.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Монгол Улсын үндэсний номын сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Монгол Улсын үндэсний номын сан нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Acoulous 3.0" программ хангамж ашигладаг байна.

Монгол Улсын үндэсний номын сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Монгол Улсын үндэсний номын сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,421,517.0 мянган төгрөгөөс тооцон 28,430.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 2.0 хувиар буюу 34,122.9 мянган төгрөгөөр тооцсон нь эрсдэлийн түвшин “бага”, ажил гүйлгээний тоо харьцангуй багатай холбоотой болно.

2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монгол Улсын үндэсний номын сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 184,658.5 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	153.3	0.8	(152.5)
Авлага	27,477.9	4,295.1	(23,182.9)
Урьдчилгаа	8,341.7	29,118.7	20,777.0
Бараа материал	122,151.8	91,252.2	(30,899.6)
Үндсэн хөрөнгө	6,245,539.7	6,094,339.1	(151,200.7)
Нийт хөрөнгө	6,403,664.4	6,219,006.0	(184,658.5)
Өр төлбөр	6,520.2	6,634.6	114.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,397,144.2	6,212,371.3	(184,772.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,403,644.4	6,219,006.0	(184,638.2)

Авлага дансны үлдэгдэл буурсан нь Азийн сонгодог бүтээлийг дижитал хэлбэрт оруулах /ACIP/ төслийн санхүүжилт мөн Шинжлэх ухаан технологийн сангийн төслийн санхүүжилтийн үлдэгдлийг 2018 оны жилийн эцэст татан төвлөрүүлснийг буцаан олгосонтой холбоотой байна. Авлага дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн 3,980.8 мянган төгрөг, он дамжсан 314.2 мянган төгрөг байна. Нийт 4,295.1 мянган төгрөгийн авлага үүссэнээс байгууллагаас авах 3,421.4 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 873.7 мянган төгрөг байна. Он дамжсан 314.2 мянган төгрөгийн авлагыг бүрэн барагдуулах боломжтой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 30,899.6 мянган төгрөгөөр буурсан нь нөөцөд байсан сэлбэг хэрэгсэл, бараа материалыг байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад ашигласан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 90,959.9 мянган төгрөгөөр өссөн нь Улсын төсвийн хөрөнгөөр 71,297.5 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 33,718.4 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үнэ төлбөргүй шилжүүлсэн, акталсан үндсэн хөрөнгө байхгүй болно.

Өр төлбөр дансны үлдэгдэл 151.1 мянган төгрөгөөр өссөн нь хувь хүнд цалин дутуу олгосноос үүссэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн 645.2 мянган төгрөг, өмнөх онуудад үүссэн 5,989.4 мянган төгрөг байна. Нийт өр төлбөрийн 90.2 хувь нь өмнөх жилүүдэд үүсэн өр бөгөөд Улаанбаатар дулааны сүлжээ ХК-тай байгуулсан дулааны цогц төхөөрөмжийн дамжуулан зээлдүүлэх гэрээний үлдэгдэл төлбөр 4,749.8 мянган төгрөг байна. Энэ нь нийт өр төлбөрийн 72 хувийг эзэлж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,212,371.3 мянган төгрөг болж 184,772.9 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа богино тогтоосноос шалтгаалжээ. Энэ нь элэгдлийн зардал өндөр гарч, нийт өртгийг бууруулж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 14,056.0 мянган төгрөгийн бичилт нь 2018 оны үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийснээс хойш үндсэн хөрөнгийн сайжруулалт хийсэнтэй холбоотой байна. Энэ нь дахин үнэлгээ хийхээс өмнөх засварын зардлыг дахин үнэлгээ хийсэн дүн дээр нэмж капиталжуулсныг залруулсан болно.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын үндэсний номын сан тайлант онд гүйцэтгэлээр 38,375.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж Сангийн сайдын 2019 оны 74 тушаалын 4.3, 4.4 дэх заалтыг мөрдлөг болгон (төлөвлөгөөнөөс давсан орлого) дээд шатны байгууллагын зөвшөөрлөөр нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх соёл, урлаг (71,702) хөтөлбөрт зориулан 1,221,015.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,208,135.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 11,880.0 мянган төгрөгийг эрдэм шинжилгээний зардалд, 1,000.0 мянган төгрөгийг тэтгэмжийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,221,015.30 мянган төгрөгийг буюу 100 хувь улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,200,268.3 мянган төгрөг буюу 98.3 хувьтай байгаа нь цалин хөлс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Гадаад төсөл хөтөлбөрт 176,647.3 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 92,154.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд 38,375.2 мянга, нийт 307,329.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс гадаад төсөл хөтөлбөрт 173,303.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 91,222.7 мянган төгрөгийг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 34,316.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 8,487.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 16 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 40,571.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 14,056.0 мянган төгрөгийн алдааг залруулж 15,586.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 10,929.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 14,056.0 мянган төгрөгийн бичилт нь 2018 оны үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийснээс хойш үндсэн хөрөнгийн сайжруулалт хийсэнтэй холбоотой байна. Энэ нь дахин үнэлгээ хийхээс өмнөх засварын зардлыг дахин үнэлгээ хийсэн дүн дээр нэмж капиталжуулсныг залруулсан болно.

Аудитаар дараах 15,586.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Даавуун өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах 13,200.0 мянган төгрөгийн тендерийг үнэлгээний хорооны гишүүд тендер хянан үзэх хуудсаар үнэлээгүй, тендерийг цахимаар зохион байгуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д *“Тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавх болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадлна”* гэсэн заалттай нийцэхгүй, оршин байдал буюу гарч тохиолдох, иж бүрэн байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөрчлийг арилгах, албан шаардлага өгөх

2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтыг бүрдэл дутуу 2,386.2 мянган төгрөгийн ажил гүйлгээг данс бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д *“Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”*, 13.7-д *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”* гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, үнэн зөв байдал, иж бүрэн байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөрчлийг арилгах, албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн 10,929.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Өрнө дахины сан хөмрөг дэх 616,167 номын бүрэн тооллогын комиссын тайлан, Түвд, эртний ховор номын бүртгэлийн явцыг авч үзэх, Үндэсний номын санд хэрэгжиж байгаа Азийн сонгодог бүтээлийг дижитал хэлбэрт оруулах /ACIP/ төслийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын үндэсний номын сангийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 27 мэдээллийг хугацаанд нь, 123 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 799.6 мянган төгрөгийн зөрчил арилгах 3 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Нийт 27,798.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Улсын үндэсний номын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 26,515.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийн дүн бидний тооцсон 28,430.3 мянган төгрөгийн материаллаг байдлын дүнгээс бага тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй” дүгнэлт

Монгол Улсын үндэсний номын сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 4,295.1 мянган төгрөгийн байгууллага, хувь хүнээс авах авлагатай байна.

3.1.2 Эрсдэл: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг мөрдөхгүй байх,

3.1.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “20 дугаар зүйлийн 20.2.5-т дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах,

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хувь хүмүүсээс авах авлага 777.1 мянган төгрөг үүссэн нь хувь хүмүүсээс ном худалдан авсан төлбөр давхар шилжсэн, ажиллагчидтай холбогдсон авлага 96.5 мянган төгрөг байгаа нь цалингаас суутгал дутуу суутгаснаас авлага үүссэн. Мөн гадаадын хөрөнгөөр санхүүжиж буй төслийн санхүүжилтийг төвлөрүүлснийг буцаан олгохоор тооцон 3,421.4 мянган төгрөгийн авлага үүссэн.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: 2019 оны 12-р сарын 31-ний байдлаар харилцагч байгууллага, хувь хүнд 6,634.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэл байна.

